

**НҮҮДЛИЙН СОЁЛООС СУУРИН СОЁЛД ШИЛЖСЭН
ШИНЖААНЫ ОЙРАДУУДЫН ҮГИЙН САНГИЙН ОНЦЛОГ
(хэлц, хэллэгийн жишээгээр)**

С.Батхишиг

Орломжав

Түлхүүр үг: *Шинжааны ойрад, хэлц хэллэг, нүүдлийн соёл, суурин соёл, хэлний өөрчлөлт*

1. УДИРТГАЛ

Хэрэв Монголын нүүдэлчдийн соёл иргэншлийн онцлогийг хэлний илэрхийллээр зуучлан судалж байгаа бол уг асуудлын судлагдахуун нь чухам юу байх ёстой юм бэ гэсэн асуулт зайлшгүй гарна. Тэгвэл ардын үлгэр домог, ерөөл магтаал, туульс, ардын дуу шүлэг зэрэг билиг сургаалын зүйлсээс авхуулаад зүйр цэцэн үг, өвөрмөц, хэвшмэл хэллэг, оньсого таавар зэрэг хэлний тогтвортой илэрхийллүүд юуны түрүүнд судалгааны хэрэглэгдэхүүн болох юм (Баянсан Ж. 2016:27). Тиймээс монгол хэлний үгийн сангийн судалгаанд тогтмол хэлц хэллэгийн судалгаа чухал байр эзэлж ирсэн билээ. Монгол хэлний хэлц хэллэгийн утгыг тодруулах, тайлбарлах зэргээр үндэстний сэтгэлгээний онцлогийг гаргахаас гадна сүүлийн үед тогтмол хэлц, хэвшмэл хэлц, зүйр цэцэн үгийн тухай онол ойлголтуудад тулгуурласан хоёр хэлний харьцуулсан, зэрэгцүүлсэн хэлц хэллэгийн судалгааны бүтээлүүд гарчээ. Харин нэг хэлний доторх хоёр нутгийн аялгууны баримтыг судалсан бүтээл хараахан гараагүй байна.

Монгол үндэстэн түүхийн явцад нийгмийн нэгдэл, задралаас шалтгаалсан олон нутгийн аялгуутны хэл, аялгууны зөрүүтэй болж байна. Нүүдэлчин монголчуудын зарим хэсэг нь нэлээн эртнээс суурин соёлтой болжээ. Хоёр өөр улсад, хоёр өөр соёл, нийгмийн харилцаанд байгаа нэг хэлтний хэлний соёл ямар онцлогтой болж хөгжиж байгааг хэлц хэллэгийн жишээгээр тодруулах нь нутгийн аялгууны бодот байдлыг тодорхойлох судалгаанд хамаарна. Тиймээс энэ өгүүлэлдээ *нэгдүгээрт*, Шинжааны ойрадуудын хэлний байдлыг танилцуулах, *хоёрдугаарт*, хэлц, хэллэгийн утгын болон үгийн сангийн өөрчлөлтөөр нэг хэлний доторх хоёр нутгийн аялгуутны хэлний соёлоор дамжуулан хэлний өөрчлөлт, онцлогийг тодруулахаар зорьсон юм.

1. 1. Шинжааны ойрадын одоогийн газар зүйн байршил, хүн ам, аж ахуй

Юуны өмнө Шинжааны ойрадуудын хэлний байдлыг бодтой танилцуулахын үүднээс тэдний харьяалал, суурьшиж буй газар нутаг, хүн ам, хил залгаа болон холилдон суугаа үндэстэн угсаасан, эрхэлж буй аж ахуй, түүхэн байдлыг дэлгэрүүлэн өгүүлье.

Тэдний голлон суух Тэкэс сянь (Tekes County) бол Бүгд Найрамдах Хятад Ард Улсын баруун хойд хязгаарт байрладаг Шинжаан Уйгар Өөртөө засах орны Илийн Казак үндэстний өөртөө засах жуугийн 8 сянь-ий нэг нь болох ба Тэнгэр уулын хойд хормой, зүүнгар Хотгорын зүүн үзүүр дэх Илийн голын дээд урсгал болох Тэкэс голын сав газрын зүүн хэсэгт байрладаг. Газрын байршил нь далайн түвшнээс 850-1500 м өндөр, 42°22'30"N-43°25'30"-81°19'00"-82°37'30"E болох бөгөөд зүүн хойд талаараа Төгстариа шянь, зүүн талаараа Баянгол монгол үндэстний өөртөө засах жуугийн Хэжин шянь, баруун талаараа Монголхүрээ шянь, өмнө талаараа Цэн шянь, хойд хэсгээрээ Цавчаал Шивээ үндэстний өөртөө засах шяньтай хил залгаж буй малжих¹, тариаланжих соёл хосолсон уулархаг газар оронд багтана.

Тэкэс гэдэг үгийн тухай олон янзын тайлбар бийгээс хоёр нь эрдэмтэн судлаачдын санал, баримтад тулгуурласан байна. Нэг нь түрэг төрлийн хэлний *тэх² ямаа* гэсэн утгатай үг, нөгөө нь монгол хэлний *тэгш* хэмээх үгний дуудлага хувьссан хэлбэр юм.

Тэкэс шянь нь 1 балгас, 7 шянь, 6 малжлын талбайгаар бүрэлдэж казак, хятад, уйгур, хотон, монгол, хиргис зэрэг 33 үндэстэн төвлөрөн суурьшиж буй. 2018 оны хүн амын бүртгэлийг үндэслэвэл, Тэкэс шянь-ий хүн ам 17 түм өнгөрч, цөөн тоот үндэстний хүн амын тоо 14 түмд хүрч, бүх шянь-ий хүн амын 81. 55%-ийг эзэлж байна. Үүний дотор казак үндэстэн 7. 6 түм, бүх хүн амын 44. 55%, хятад үндэстэн 3. 15 түм, бүх хүн амын 18. 45%, уйгур үндэстэн 1. 97 түм, бүх хүн амын 11. 55%, Хотон үндэстэн 2. 45 түм, бүх хүн амын 14. 37%, киргиз үндэстэн 1. 17 түм, бүх хүн амын 6. 55%, монгол үндэстэн 0. 44 түм, бүх хүн амын 2. 6%-ийг эзэлж байна.

Бүх Шинжааны 18 түмэн монголчуудын 5 мянга гаруй нь тус сяньд суурьшиж байна³. Тэкэсийн Монголчууд бол *өөлд, торгууд, хошууд, дөрвөд* зэрэг ястнаас бүрэлдэж Тэкэс шянь, Хужирт монгол шянь, Хужиртохой, Бахлаг, Хартохой, Хардалай, Улаанхүрээ, Чилүчүк зэрэг шянь балгас, сум, тосгоноор тархан сууж байна. Өөлд, торгууд ястан зонхилох тоо эзлэх тул хэл ярианы хувьд өөлд, торгууд аман аялгуунд багтдаг гэж судлаачид үздэг.

1. 2. Шинжааны Ойрадын түүхийн товч

Тэкэс шяний монголчууд бол 1771 онд Увш хааны удирдлагаар торгуудуудтай эх нутагтаа буцаж ирсэн Хутагт гэгээн Зая бандид ба түүний иргэн шавь Алдар гавжийн шавь нарын хойчис болно. Сурвалж бичгийг үндэслэвэл, “Тэкэсийн дөрвөн суман шавь нар” нь 1640 оноос эхлэн дөрвөн ойрадын зүүнгар (өөлд), торгууд, хошууд, дөрвөдөөс “Хутагт гэгээн Зая бандида”-д өргөсөн албат учраас “Барьцын шавьнар” гэж ч хэлдэг. Тэд Галдан бошигтын дайны үед буюу арван долдугаар зууны сүүлчээр хүрээ нь тархаад нэг хэсэг нь Төвд, Хөхнуурт нүүж очоод, нөгөө хэсэг нь зүүнээ гагар өөлдийн жасаануудад шингээд, мөн нэг хэсэг нь Ижилд очоод Аюухи ханы дэмжлэгээр “Хүрээ”-гээ дахин сэргээж байгуулжээ.

1771 онд Увш ханы удирдлагаар доорд лам Луузанданзан, Ашиг тайж, Туг-Ёндон, Иш-Ёндон нарын дагуулснаар торгуудуудтай эх нутагтаа буцаж ирсэн “Хутагт гэгээний шавьнарчуудын Алдар гавжийн шавьнарт багтана”. Ижилээс түм илүү хүн амтай гараад зам зуур үхэл үрэгдэлтэй нүүр тулж Ил-д ирэхэд найман зуун жар орчим хүн амтай үлджээ. Тухайн үеийн Ил-ийн жанжин Сүхдэй Шавьнарчуудыг уг нутаг Ил Тэкэс-т нь байршуулахдаа урьдаар Илийн “Өөлд хороо”-ны баруун гарын доорд таван хошууны Өгөөдэй Шодонд харьяалуулан таван хошууны арван суманд хэсэг хэсгээр ангилан хуваажээ.

¹ Нүүдлийн мал аж ахуй биш суурин мал аж ахуйг заана.

² Тэх [teke] ‘эр янгир’ || Cf. Turk. taka ‘козел’ (Радлов, III: 1016), AT tekä ‘козел’ (ДТС, 550), tekē ‘he goat’ (Clauson 477); Man. texe ‘козел’ (Цинциус. II:236) || Ж = oqraba teke [козел блял] (Mu. 267) || Kha. tex, Ord. dekxe, Bur. texe, Oir. tek (Д.Төмөртоогоо, 2018-263-264).

³ Тэкэс сянь дахь ганц монгол хэлний сурган хүмүүжлийн нэгж болж байсан 4-р дунд сургууль нь 2008 онд хаагдсан боловч нийгэм, амьдралын хүрээнд монгол хэлээ хэрэглэсээр байна.

Нэг хэсэг шавьнар нь Хошуудын Хөнхийн харьяанд Жулчад нүүж одсон байна. Эдний хойчис нь одоогийн Хошууд шянд байх Шавьнар сум болно.

1772 онд, Тэнгэр тэтгэгч хаан жанжин Сүхэдэйд: “Илид харьж ирсэн шавьнар бол хутагт Равжимбын шавьнар болно. Тиймээс шарын шашин шүтнэ. Эднийг өөлд хорооны дотоод таван хошууны арван зангийн газар оронд хувааж тархаагаад байршуулсанд шашны ном уншихад аягүй болж шашны хэрэгт их нөлөөлжээ. Шавьнар ажилд торгуудтай хамт нэг газар байсан боловч хүрээ дацан нь талдаа шашны ном хурлаа үйлдэж явжээ. Өдгөө өөлдийн арван зангийн тав нь илүү, үүний дотроос дөрвийг нь шалгаж аваад, шавьнар нутгийг тахиж нэг газар хураагаад дөрвөн сум хувааж “шавь дөрвөн сум” гэж нэрийдээд, Өөлдийн Өгэрдэй Шодонгийн захиргаанд харьяалуулжээ. Ингэж “дөрвөн сум” хуваахдаа хуучин уг гарлыг нь үндэслээд арван хэдэн өөлдийг нийлүүлэн нэг хэсэг хошууд ястан (дөрвөн ястан багтана)-аар бүрэлдсэн шавь нарыг Хөл улаан (Үж суман), нэг хэсэг торгууд ястнаар бүрэлдсэн шавь нарыг Хөл хөх (Үж суман), нэг хэсэг өөлд ястнаар бүрэлдсэн шавь нарыг Хөвөөт цагаан, нэг хэсэг дөрвөд ястнаар бүрэлдсэн шавь нарыг Хөвөөт улаан гэж хуваагаад Тэкэсийн голын доод сав газарт байршуулжээ. Үүнээс эхлээд “Тэкэсийн дөрвөн сум шавь нар” гэх буюу уг гарлыг нь үндэслэн “Хутагт гэгээний дөрвөн суман шавь нар” гэж нэрлэжээ. Энэ бол даруй хутагт Гэгээн болон түүний иргэн шавь Алдар гавжийн шавьнарын хойчис юм. Тэд “дөрвөн сум” болж хуваагдсан тул тэр цагаас аваад улс чөлөөлөгдөх үе хүртэл ерөнхийдөө холилдон суусан бөгөөд Хөлхөх сум талдаа байсан буюу угаасаа Шавьнарчуудын “Хутагтын хүрээ”, “Алдар гавжийн хүрээ”, “Элчийн арваны хүрээ”, “Бабо-гийн аравны хүрээ” шүтлэг шүтэж, тахилга нь тал талдаа байсан байна. Хөлхөх сум нь нөгөө гурван сумаа “Гурван суман” гэж, гурван сум нь Хөлхөх сумаа “Энхийн суман” гэж нэрлэдэг. Учир нь Ижилээс иргэдээ дагуулан ирсэн Туг-Ёндоны жич Лийж Илгэдэйн хөвгүүн Энх 1870 оны үесээр Хөлхөх суманд удаан жил занги сууж нутаг дундаа их хүндтэй явсан болохоор “Энхийн суман” гэсэн нэр бүдгэрчээ.

2. СУДАЛГААНЫ ТОЙМ

Монгол хэлний өвөрмөц хэлц, хэвшмэл хэлцийн талаар тусгайлан судалсан мөн бусад хэлтэй харьцуулсан судалгааны бүтээл багагүй гарчээ. Тухайлбал, Ж.Баянсан *Соёл, хэл, үндэстний сэтгэлгээ* (2016), Ц.Онон, *“Монгол япон хүний сэтгэлгээний нийтлэг ба өвөрмөц онцлогийг хэлний илэрхийллээр шинжлэх нь /гэр бүлийн хамаат үг хэллэгээр/* (УБ., 2013), Т.Мөнхжаргал, *“Солонгос хэлний өвөрмөц хэлцийг хэл, соёлын шүтэлцээнд судлах нь”* (УБ., 2012), Л.Ганчимэг, *“Монгол хэлний хэлц нэгжийн бүтэц утга зүйн тогтолцоо”* (УБ., 2010) зэрэг ганц сэдэвт зохиолоос гадна олон өгүүлэл, толь бичиг буй. Нөгөөтэйгүүр Шинжааны Ойрадын үг хэллэгийн холбогдолтой баримт материал ч цөөнгүй байна. Түүнээс дурдвал, Х.Дамиранжав нарын найруулсан *“Илийн соёл түүхийн материалын Монгол үндэстний тусгай эмхэтгэл”* (Шинжааны ардын хэвлэлийн хороо, 2004), Лүнтү *“Ойрад нутгийн аялгууны үгсийн хураангуй”* (Өвөр Монголын Их Сургуулийн хэвлэлийн хороо, 1994), 3. Чойжинжав нар найруулсан *“Монгол төрлийн хэл аялгууны судлалын цуврал -21”*, *“Ойрад аялгууны үг хэллэгийн материал* (Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 1987), Үнэнч, Ч.Ринчен нар найруулсан *“Дөрвөн бичиг хавсаргасан ойрад аялгууны үгсийн толь”*, (Шинжааны Ардын Хэвлэлийн Хороо. 2005), Н.Сүрүүн, Сайнбулаг, Булга нар найруулсан *“Ойрад аялгууны өгүүлүүд”* (Шинжааны ардын хэвлэлийн хороо, 1997), Т.Булга *“Ойрад аялгууны судлал”* (Шинжааны ардын хэвлэлийн хороо, 2005), Ц.Норжин нар найруулсан *“Нутгийн аялгууны үгсийн хураангуй”* (Үндэсний хэвлэлийн хороо, 1992), Боржигин Баярмэнд *“Монгол хэлний нутгийн аялгуу ба монгол соёл* (Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 1999) зэрэг Шинжааны ойрадын хэл соёлтой холбогдох бүтээлүүдийг дурдаж болно.

3. СУДАЛГААНЫ АРГАЗҮЙ

Хэлц нь цаг үеийн жамаар зарим нь хуучирч идэвхгүй үгийн сангийн нөөцөд шилжих буюу хуучрах мөн шинээр үүсэх зэргээр үргэлжид хувиран өөрчлөгдсөөр иржээ (Төмөрцэрэн Ж. 2001:137-145). Шинжааны ойрадын аялгуунд ч хил залгаа суугаа үндэстэн, холилдон суугаа үндэстний хэл нөлөөлж, хос, холимог хэлтэн болсны улмаас түүхийн урт хугацаанд янз бүрийн соёлын нөлөө тэдний хэлц, хэллэгт тусч өөрчлөгджээ.

Зохиогчид энэ өгүүлэлдээ Бүрэнтөгсийн “Монгол хэлцийн далай” хэмээх хэлцийн толь бичгийг сурвалж болгон ашигласан бөгөөд тэрхүү толь бичигт тэмдэглэсэн хэлц үгсийг Шинжааны ойрадад өөр үгийн сан бүхий хэлцээр хэлж байгаа, эсвэл уг тольд тайлбарласан утгаас өөр утгаар ойлгож байгаа хэлц, хэллэг, бүр огт ойлгогдохгүй болсон хэлц хэллэгийг юун түрүүн түүж багцалсан юм.

Суурин соёлд холбогдох хэлц хэллэгийг түүвэрлэх эхний шалгуур нь нүүдлийн мал аж ахуй, уламжлалт монгол мэдлэг ухаантай холбогдох хэлц хэллэгийг Шинжаан Ойрадад өөрөөр хэлэх болсныг, тухайлбал тариалангийн соёлтой холбогдох үгсээр хэрхэн орлуулсныг авч үзсэн. Хоёрдахь шалгуур нь Шинжааны ойрад аман аялгуутан нь тухайн бүс нутагтаа уйгар, хасаг, хотон зэрэг олон үндэстэнтэй холилдон сууна. Тиймээс уйгар, хасаг болон хятад хэл, соёлын нөлөө бүхий үгс бийг тодруулж нягталлаа.

Дээрх аргазүйгээр ойролцоогоор 500 гаран хэлцийг бүртгэн үзэхэд Бүрэнтөгсийн тольд орсон үгсээс Шинжааны ойрадад өөр үгийн сангаар хэрэглэх болсон үгс, үгийн санг нь тэр хэвээр хэрэглэж буй боловч утга нь шилжсэн үгс, мөн ойрад нутгийн аялгууны үг бүхий хэлц хэллэг, хамтарч суугаа соёлын нөлөөгөөр хятад, уйгар, хасаг хэлний үгийн сантай холилдон орсон үгс, эсвэл хятад, уйгар, хасаг хэлний шууд орчуулга, соёлын нөлөөтэй үгс гэж ангилж болмоор байна.

4. ШИНЖААНЫ ОЙРАДУУДЫН ХЭЛНИЙ ОНЦЛОГ

Тухайн үндэстний түүхэн хөгжлийн цаг үе алсрахын хэрээр гадаад нөхцөл байдал тасралтгүй аажим аажмаар хувиран өөрчлөгдөхийн зэрэгцээ үндэстний зан суртахууны өвөрмөц онцлог, өвөрмөц байдлыг бий болгож байсан олон хүчин зүйл, олон шалтгаан нөхцөл ч сарнин үгүй болж болно (Баянсан Ж. 2016:25).

Шинжааны ойрадуудын хувьд суурин соёл, наймаа арилжаа, өөр хэлний орчуулгын нөлөө зэрэгтэй холбоотойгоор өөр утгаар юм уу, утга бүдгэрч марагдсан, утга нь шилжсэн хэлц хэллэг арвин байна. Жишээ нь, Бүрэнтөгсийн “Хэлцийн далай”-д *мал дарах* гэдэг хэлц нь ‘малыг бэлчээр өөд нь хөөх, бэлчиж яваа малыг өөр тийш чиглүүлэх, малын тоог дутуу мэдүүлэх’ гэсэн утгатай гэж тайлбарласан бол Шинжааны ойрадад ‘ачааны машинд мал ачих’ гэсэн дан ганц утгаар хэрэглэх болжээ. Мөн *өнгө татах* гэдгийг Бүрэнтөгсийн “Хэлцийн далай”-д *хувцас хунар гадарлах, гэрэл татах* гэсэн утгыг заана гэсэн бол Шинжааны ойрадад ‘найзалж нөхөрлөхийг өнгө татах’ гэнэ. Түүнчлэн суурин мал аж ахуйтай болсон тул бэлчээр нь өмчийн болж хашаанд өвс тэжээл өгч тэжээх тул хашаанаас гаргах гэсэн санаагаар Шинжааны ойрадад ‘үхэр гаргах’ гэж ярина. Үүнийг Бүрэнтөгсийн ‘Хэлцийн далай’-д *үхэр залах* гээд ‘үхрийг бэлчээр өөд нь хөөх, чиглүүлэх’ гэсэн утгатай гэж тэмдэглэжээ.

Нүүдэлчин соёл, мал аж ахуйгаас холдож, түүнд холбогдох хэлний онцлог бүдгэрч буйн бас нэгэн жишээ ‘хэнз хурга’ гэж Шинжааны ойрадад ярилцахгүй болж харин хүний отгон, айлын ганц хүүхдийг *хэнз хүүхэд* гэх болжээ.

Түүнээс гадна Шинжааны ойрадад утга нь бүр ойлгомжгүй болсон хэлц хэллэгүүд байна. Тухайлбал, Бүрэнтөгсийн тольд орсон *хээрээр гэр хийж хэцээр дэр хийх, хээр хонож хэц дэрлэх* гэдгийг Шинжааны ойрадад ойлгохгүй. Бүрэнтөгсийн “Хэлцийн далай”-д

орсон ам хэл сугалах шахах гэдэг нь 'хүнээс олон асуулт угсруулан шаглан асууж үг өчих завгүй болтол цариун ярих байдал' гэсэн бол Шинжааны ойрадад зөвхөн *хоол амттай* гэсэн утгатай. Гаднын соёлын нөлөөгөөр халуун ногоотой хоол идэх болж, тэр нь хэл ам дарвигнуулахыг амттайгаар мэдрэх болсноор хоолны амттайг 'хэл ам сугалах шахах' гэж зүйрлэн ойлгож байна. Мөн Бүрэнтөгсийн "Хэлцийн далай"-д *гар тавих* гэдэг хэлц нь 'сэтгэл амрах, зодохыг эерүүлэх хэллэг, ихэд хүндэлж асрах, гардаж хийж байсан зүйлийг хийхгүй, хамаарахгүй орхин тэвчих гарын мутраа адислах' зэрэг утгатай гэсэн бол Шинжааны ойрадад 'гарын үсэг зурах, мөн хулгай хийх' гэсэн утгатай болсон байна.

"...Харь хэлний үг, зарим холбоо үг, түүнчлэн зарим өгүүлбэрийн бүтэц нь тухайн хүнд эхэндээ хачирхалтай сонин, нэг янзын "этгээд гаж" (аномали) юм шиг сэтгэгдэл төрүүлдэг нь чухамдаа төрөлх хэлнийх нь ассоциаци, аналогий давамгайлж байгаагийн шинж болно. Харин уг үзэгдэлд нэгэнт дадаж зуршсаны хойно энэ "гаж" байдал мэдрэгдэхээ больдог (Баянсан Ж. 2016:145). Үгийн сангийн хувьд ч энэ "гаж" байдал Шинжааны ойрадын хэлэнд нөлөөлжээ. Жишээ нь, *айлд таарахгүй, амьтантай нийцэхгүй* гэсэн хүний зожиг зөрүүд зан байдлыг дүрсэлсэн хэллэгийг Шинжааны ойрадад '*ойрт нь өвс ургахгүй*' гэж илэрхийлэх ба нүүдлийн соёлын 'айл' гэх ойлголтыг 'айл хүний амь нэг' гэдэг шиг хамтын нийгмийн хэв заншлаар ойлгохгүй болжээ. Тиймээс *зөрүүд зожиг хүний занг ойр хавьд нь өвс ч ургахгүй* гэж зүйрлэсэн нь жилийн дөрвөн улиралд өвс ногооны ашиг шимийг дагаж нүүдэллэдэг монгол ахуйгаас холдож суурин суух соёлтой холбогдож үгийн сан, өгүүлбэрийн найруулга нь "гаж" бус болжээ. Мөн *уулын бугыг хараад унасан бухаа хаяна* гэсэн 'ихийг үзээд багыг голох, бусдынхыг үзээд өөрийнхийгөө адлах зан'-г заасан хэллэгийг Шинжааны ойрадад '*хүний юм хүүхэн болох, өөрийн юм эмгэн болох*' гэж хэлж байна.

Ер нь Бүрэнтөгсийн "Хэлцийн далай"-д буга, бух, таван хошуу малаар зүйрлэсэн хэллэгийг *хорхой, шувуу, нохой, илжиг* зэргээр зүйрлэсэн юм уу дээрх жишээний адил огт өөр хэлц хэллэгээр хэлэлцэх болжээ. Тухайлбал, *ямаан чинээ явдлыг тэмээн чинээ болгох* гэдгийг Шинжааны ойрадад 'малгай авна гэвэл толгой авах', *нэг тэмээний хорголд мянган тэмээ хальтирдаг* гэсэн нэг хүний уршгаар олон хүн нөлөөлөгдөх гэх утгатай хэлцийг Шинжааны ойрадад '*баасаа цацах, ачаагаа халдайх*' гэж огт өөр зүйлээр адилсуулан хэрэглэж 'ямаа, тэмээ'-тэй хэлцийг мартсан нь уг үзэгдэлд нэгэнт дадаж зуршсан хэрэг юм.

Бас нэгэн сонирхолтой зүйл бол урт удаан түүхийн хугацаанд хөрш зэргэлдээ юм уу, хамт сууж зан зангаа мэдэлцэх болсноор бусад үндэстэн, ястныг үнэлэх үнэлэмж бий болсон нь Шинжааны ойрадын хэлц хэллэгт тусчээ. Жишээ нь, *ааш хөдлөх* гэсэн муу зан илрэхийн утгатай хэлцийг Шинжааны ойрадад '*Ордос ад нь хөдлөх, Ордос нь хөдлөх*' гэдэг байна. Бүрэнтөгсийн "Хэлцийн далай"-д тэмдэглэсэн '*бөгсийг нь алгадах*' гэсэн *хөөжс явуулах*, аргадаж явуулах зэргийн утгыг Шинжааны ойрадад '*хошигиногоор Хотон тором тавих*' гэж хэлэлцдэг байна. Урамгүй унжийх зэрэг жавхаагүй байдлыг Шинжааны ойрадад *Жан алдсан хотон шиг* гэж хэлэлцэнэ. Мөн Бүрэнтөгсийн тольд тэмдэглэсэн '*өр алдсан хятад шиг*' гэсэн сэтгэлээр унаж бодлогоширон гиюүрэхийг үл таашаасан хэлцийг Шинжааны ойрадад '*жан⁴ [dʒaŋ] алдсан хотон шиг*' гэнэ.

4. 1. Ойрад нутгийн аялгууны онцлог бүхий хэлц хэллэг

Шинжааны ойрадын хэлц хэллэгийн ойрад аялгуутай холбоотой хэсгийг авч үзвэл монгол хэлний түүхэн хувьсал хөгжлийн онцлог, түүнд холбогдох нутгийн аялгууны баримт гол төлөв харагдана. Тухайлбал, хамжин шүргэх *dz* авиалбарыг хамжих *d/t*-гээр дуудахын жишээ *халз таарахыг* Шинжааны ойрадад *халт таарах* [xalt ta:rx], *халт мөргөлдөх* [xalt mǝrgǝldx], *халт харгалдах* [xalt xargǝldx] гэнэ. Мөн халхын аялгуунд *о*-г ойрадын аман аялгуунд *э*-гээр дууддагийн жишээ үг сөхөх гэдгийг үг *сэхэх* [sə:kik], халхын аялгуунд

⁴ Жан (账 zhang) нь өр гэсэн хятад үг.

хэлзүйн харьцаанд гарч ирдэг “тогтворгүй -н” ойрад аман аялгуунд тогтвортой буйн жишээ болох *бараа болох* гэхийг *бараан болох* [ba:ra:n bɔlx], бараа сураггүй гэхийг *хараан бараангүй* [xara:n ba:ra:n gɔ] гэх мэт. Бас нэг сонирхолтой зүйл хэлц хэллэгийн жишээнд буй нь эртний монгол хэлний олон үгийн эхэнд байсан гийгүүлэгчийн хувьсал, түүний махбод ойрад аялгуунд хадгалагдаж байна. Жишээ нь, *нүд ухах* гэдгийг Шинжааны ойрадад *нүд хучилах* [xɔʃlɔx], *нүдээ чичлүүлэх* гэхийг Шинжааны ойрадад *нүдээ хумхлах* [xɔmkɔlx] гэхчлэн илэрч байна.

Нөгөө талаар нутгийн аялгууны онцлогт үгийн санг хэлц хэллэгийн бүрэлдэхүүнээс харж болно. Бүрэнтөгсийн ‘Хэлцийн далай’-д тэмдэглэсэн *хуартай хүн* гэснийг Шинжаан Ойрадад *залим хүн* [dʒælm kun] гэж нэр үгээс тэмдэг нэр үүсгэн зальтай гэсэн утгыг илрүүлжээ. Мөн хүү *идэх* гэдгийг Шинжааны ойрадад *өсөм* [ɔ:sɔm] *идэх* гэнэ. Өс- гэсэн үйл үгээс нэр үг үүсгэж бүтжээ. Өвөр монгол, Монгол улс дахь олон нутгийн аялгууны *чоно* гэдэг үгийг Шинжааны ойрадад *боохолдай* [bɔ:xɔldæ] гэж хэлнэ. Жишээ нь хэлц хэллэгт *амьд явбал ачаатай боохолдай* [bɔ:xɔldæ] *үзнэ* гэж ачаатай чоно хүний амьдралд тааралдахгүйтэй адил боломжгүй, баймгүй зүйл ч хүний амьдралд тохиолдож болох утгыг *боохолдай* [bɔ:xɔldæ]-аар зүйрлэжээ.

Мөн авиа дуурайх үгээр монгол хэлний нутгийн аялгуудад авиа сэлгэдэг авианзүйн хувьслын онцлогийг хадгалсан хэллэг ч бас тохиолдож байна. Бүрэнтөгсийн “Хэлцийн далай”-д тэмдэглэсэн *нал нал хийх гэсэн* дэмий олон үг чалчихыг үл таашаасан хэллэгийг Шинжааны ойрадад *хал хал* [xal xal] *хийх* гэнэ. Хэрэлдэх муудалцах зэргийн утгыг Шинжааны ойрадад *кар күр* [kɑr kʊr], нарийн чанга дуугаар инээхийг Шинжааны ойрадад *гош гош* [gɔʃ gɔʃ] гэх мэтээр илэрхийлдэг ажээ.

4. 2. Уйгур, хасаг хэл, соёлын нөлөөтэй хэлц хэллэг

Ер нь Шинжааны ойрадууд уйгар, хасагуудтай холилдон сууж, уйгар хасаг хэлний үгийн сангаар их хэлэлцэнэ. Хэл хэллэгт нь ч цөөнгүй уйгар, хасаг хэл соёлд хамаатах үгийн сан таарч байна. Тэдгээр нь нэгдүгээрт, хэлц хэллэгийн бүтцэд шууд орж ирсэн уйгар, хасаг үгийн сан бүхий хэллэг байна. Бүрэнтөгсийн ‘Хэлцийн далай’-д *Айлчин хүнд гуталгүй, архичин хүнд зоосгүй* гэсэн ардаг танхай явах гэсэн утгатай үгийг Шинжааны ойрадад ‘Шалбараа гэсэн’ гэнэ. Шалбар [ʃalwɛr] гэдэг нь нэг зүйл өмдийг заана⁵. Бүрэнтөгсийн тольд *усан могой харвах* гэж “усан дотор маш хурдан явахыг дүрсэлсэн хэллэг”-ийг Шинжааны ойрадад *суу* [sɔ:] *могой* гэнэ. Уйгар, түрэг хэлээр усыг “суу” гэнэ⁶. Мөн Шинжааны ойрадад маш хичээмж болгоомжтойг заасан ‘Хумсаа зуусан миши [miʃ]’⁷ шиг, итгэл хүндээ барахыг заасан *нүүрээ барах, атвариа* [ætɬwɛ:r]⁸ *барах*, сохор зоос гэхийг ‘сохор тин’ [tin]⁹, *задгай зоос* гэхийг ‘парчаа’ [pɑrtʃa:]¹⁰ гэх мэт хэлц хэллэгээр хэлэлцэнэ.

Хоёрдугаарт уйгар, хасаг соёлын нөлөөтэй хэлц хэллэг байна. Жишээ нь, Бүрэнтөгсийн “Хэлцийн далай”-д *Алаг азаргаа унаж байгаад алаг азаргаа ирнэ* гэсэн дэргэдэх зүйлээ омтгойлох буюу эрж олохгүй байдлыг хошигнон зүйрлэсэн хэллэгийг Шинжааны ойрадад *Илжиг унаж байгаад илжгээ хайна* гэнэ. Энэ үгийг уйгурууд их хэрэглэнэ. Ер нь мал ахуйтай холбоот үгс санг суурин соёлын хамаат үгийн сан бүхий хэлц хэллэгээр хэрэглэж байгаагийн тодорхой нэгэн жишээ болно.

Арилгасан сармис, арчсан толь хэмээсэн хүний цэвэр сайхныг зүйрлэсэн хэллэгийг Шинжааны ойрадад *арчсан алим шиг* гэнэ. Мөн *алим эшнээсээ хол одохгүй* гэж ‘эх нь хээр

⁵ [ʃalvur] - шалбар (арьсан өмд). Р.Уяа. *Уйгур, монгол хэлний дундын үгс*. Уб. 2017, х. 74.

⁶ Р.Уяа. *Уйгур, монгол хэлний дундын үгс*. Уб. 2017, х. 56.

⁷ *Миши* нь муурыг хэлнэ. [müʃük, miʃ] (муур). Р.Уяа. *Уйгур, монгол хэлний дундын үгс*. Уб. 2017, х. 41.

⁸ Царай, дүр гэсэн утгатай уйгур хэлний үг.

⁹ Уйгур, хасаг хэлээр дамжин орсон зоос гэсэн үг.

¹⁰ [pɑrtʃ-purlt]. Жижиг сажиг, аахар шаахар, аар саар. “Уйгур-хятад онлайн орчуулгын толь”.

алаг бол унага нь шийр алаг'-ийн утгыг илэрхийлсэн байна. Уйгар, хасагууд алим ихээр ургуулдагтай холбоотойгоор алимаар зүйрлэсэн хэллэг хэлц Шинжааны ойрадын үгийн санд олон байна.

Бас Шинжааны ойрадад *малыг нь хураах* гэх мэтчилэн хэлц хэллэг байх боловч 'мал' гэдэг үг нь Шинжааны ойрадын аман аялгуунд түрэг төрлийн хэлний адил 'хөрөнгө'-ийг заахаас 'таван хошуу мал'-ыг заахгүй болжээ.

4. 3. Хятад хэл, соёлын нөлөөтэй хэлц хэллэг

Нэгдүгээрт, Шинжааны ойрадын үгийн санд хятад хэлний шууд орчуулгын тусгал болсон хэлц хэллэг байна. Жишээ нь, 'ардахь үүд хийх' (走后 门 [ou hou men]) гэж хээл хахууль өгөх гэсэн утгатай шууд үгчлэн орчуулж хэрэглэсэн байна. Мөн хятад хэлний ханзны дөрвөн үсгээр илэрхийлдэг хэлц хэллэгийн орчуулга үгийн санд нь орсон байна. Жишээ нь, нэг санаатай гэсэн утгатай "үг нь нэг, уриагаараа адил" гэсэн хэлц байна.

Хоёрдугаарт, хятад хэлний ормол үг бүхий хэлц хэллэгийн үгийн сан тодорхой хувийг эзэлнэ. Жишээ нь, *баагаа хаах* гэсэн өрөө төлөх гэсэн утгатай хэлц байна. *Баа* нь *өр*, *татвар* гэсэн хятад үг болно. Мөн эв эвдрэн муудалцахыг зүйрлэсэн "*шангийн доогуур ус гүйлгэх*" гэх мэт хэлц байна. Шан нь тариа будааны шан бөгөөд доогуур нь ус гүйлгэвэл эвдэрдгтэй зүйрлэжээ.

Ер нь хятад хэл, соёлын нөлөөтэй хэлц үгс дотор хоол хүнстэй зүйрлэсэн хэлц хэллэг олон байна. Жишээ нь, 'Хэлцийн далай'-д тэмдэглэсэн *Амьсгаан тоо барагдах гэсэн* үхэхийг ёгтлон эерүүлсэн хэллэгийг Шинжааны ойрадад *будаан дүүрэх* гэнэ. "Будаа" нь дан ганц цагаан будаа бус хоолыг ерөнхийд нь зааж буй үг болно. *Хоолны хэмжээ болох* гэсэн утгаар хэрэглэнэ. Их иддэг хүнийг шоглосон утгаар мөн Шинжааны ойрадад "хагархай ам, боорцгийн эзэн (饭桶 [fan tong]), будааны тулам, хөндий хоолойтой" гэхчлэн хэлэлцэнэ.

Гуравдугаарт, хятад соёлын нөлөөгөөр нүүдлийн соёлоос холдсоны жишээ болох 'ногоо' гэсэн үг орсон хэлцийн утга бүдгэрсэн байна. Жишээ нь Бүрэнтөгсийн "Хэлцийн далай"-д *ногоо хөөх* гэж хавар ногоо цухуйх үед мал ногоо эрж тогтолгүй явах утгатай хэлцийг Шинжааны ойрадад хэлэлцэхгүй. Энэ нь *ногоо* гэдэг нь өвс ургамлыг нэрлэх утга нь бүдгэрч зөвхөн идэшний зүйлийг заах нэрлэлт болсонтой холбоотой бололтой. Мөн Бүрэнтөгсийн тольд буй '*Байдгийг нь балбаж балин тахилыг нь хураах*' гэсэн хоосрох ядуурах, үгүйрэхийн туйлд тулах утгатай хэлцийг Шинжааны ойрадад 'байдгаа барж байшиндаа орох', 'байдгаа барж байцаандаа (白菜 baicai) орох' гэнэ. Шинжааны ойрадын хэлэнд гэр, байшин хоёр нь адил утгатай, байр байшинг заана.

5. Дүгнэлт

Зохиогчид энэхүү өгүүллээрээ юун түрүүн Шинжааны ойрадуудын хэлний байдлыг танилцуулах зорилго тавьсан. Учир нь Монгол улсад суугаа ойрад аялгуутнаас гадна олон ойрадууд БНХАУ-д суурьшжээ. Тэдгээрийн зарим нь Хөхнуурт төвд хэл, соёлтой хил залгаа сууж байна. Мөн зарим хэсэг нь Ганьсуд, Өвөр Монголын зарим хэсэгт, тухайлбал Алшаад хятад хэл соёлтой холимог, эсвэл залгаа нутагт оршин сууна. Харин Шинжааны ойрадууд нь хасаг, уйгар угсаатантай хэл соёлын харилцаатайгаараа онцлог бөгөөд мэдээж БНХАУ-д суурьшиж буй учир хятад хэл, соёлтой ч харилцаатай хөгжиж буйг тодруулахад тэдний үгийн сан чухал баримт болж байна.

Нэг хэлний доторх хоёр нутгийн аялгуутны хэлний соёлоор дамжуулан нүүдлийн соёлоос суурин соёлд шилжихэд гарсан үгийн сангийн онцлогийг харахад *нэгдүгээрт*, Шинжааны ойрадын хэл аялгуунд уйгар, хасаг, хятад хэлний үгийн сан шууд болон орчуулгын маягаар, мөн зарим талаар соёлын нөлөө тусгал нь үгийн санд нь нөлөөлснийг

харж болно. Тиймээс энэ мэт судалгаа нь уусаж буй хэл, аялгууны нөхцөл байдал, хэл аялгуу хэрхэн өөрчлөгддөг тухай судалгаа, түүний баримт хэрэглэгдэхүүнийг тодорхойлоход ач холбогдолтой.

Шинжааны ойрадууд мал аж ахуйтай холбоотой хэлц хэллэгийг суурин соёлд холбогдох өөр хэллэгээр орлуулан хэрэглэх болсон, эсвэл мал аж ахуйтай холбоотой зарим үгийн утгыг огт ойлгохгүй болсноос үзвэл монгол хэлний ойрад нутгийн аялгууны салбар гэж ангилдаг ч нүүдлийн соёлтой ойрад аялгуутан, суурин соёлтой ойрад аялгуутны хэл яриа улам бүр холдож буйг харж болно. Шинжааны ойрадууд ч мөн малжих соёлтой гэж тодорхойлогддог ч энэ бол суурин соёлын мал ахуй бөгөөд нүүдлийн соёлоос ялгаатай болсон нь хэл, түүний үгийн сангийн бүрэлдэхүүн хэлц хэллэгт ч тусаж, өөрийн хил залгаа, хамтран суугаа соёлын нөлөөнд хөгжиж байна. Сурвалж болгосон Бүрэнтөгсийн “Монгол хэлцийн далай” нь монгол бичгийн хэлээр хэвлэгдсэн Өвөр Монголын нутгийн аялгуунд тохиолдох хэлц хэллэгийг түүвэрлэн хэвлэсэн бүтээл билээ. Гэтэл нэг улс доторх Шинжааны ойрадын нутгийн аялгуунд хэрэглэгдэж буй хэлц хэллэг нь тэрхүү толь бичгийн материалаас өөр болоод зогсохгүй басхүү бусад нутгийн аялгуутан, тухайлбал бидэнд зарим талаар ойлгомжгүй болсон юм уу ойлгохгүй хэлц, хэллэг олон байна. Гол төлөв хятад хэлний орчуулга үг юм уу, хятад хэлний ормол үгийг хэрэглэсэнтэй, мөн нутаг нутгийн аялгууны үг хэллэг, халх аялгууны үүднээс авч үзвэл хуучирсан юм уу түүхэн үг хэллэг байгаатай холбоотой бололтой.

THE LANGUAGE FEATURES OF XINJIANG OIRATS MOVED FROM NOMADIC TO SETTLED CULTURE

(A case of Idioms and Idiomatic Expressions)

The paper aims at introducing the language status and explaining the language features of Xinjiang Oirats while exploring the semantic and lexical changes in idioms and idiomatic expressions and culture of two dialects in one culture.

The features of national mentality are commonly emerged in the language which is considered as a component of national culture and national character, and more specifically, it is usually interpreted by the idioms and idiomatic expressions.

A study on idioms plays a prominent role in the studies on Mongolian Lexicology. Not only it clarifies, explains and identifies the features of national mentality, but also more recent studies have been conducted on the comparison and contrast of idioms in two languages. Historically speaking, the social disintegration in Mongolia created differences in language dialects of Mongolian ethnic groups. Some of Mongolian nomads had moved to the settled culture earlier than ever before.

The main objective of the study is to clarify what the distinctive features of languages and cultures in which the speakers of two different cultures live and interact with each other. The cases of two dialects are investigated and the most commonly used idioms and idiomatic expressions are examined in this study.

Номзүй

- Бүрэнтөгс.** 2001. *Монгол хэлцийн далай*. Өвөр Монголын Сурган Хүмүүжлийн Хороо.
- Агдай О.** 1997. *Нүүдэл аж ахуйн монгол соёл*. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо.
- Базаррагчаа М.** 2003. *Монгол хэлний сүгээр ба найруулбарын тухай*. Уб.
- Баянсан Ж.** 2016. *Соёл, хэл, үндэстний сэтгэлгээ*. Уб.
- Баярмэнд.** 1999. *Монгол хэлний нутгийн аялгуу ба монгол соёл*. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо.
- Булга Т.** 2005. *Ойрад аялгууны судлал*. Шинжааны ардын хэвлэлийн хороо.
- Ганчимэг Л.** 2010. *Монгол хэлний хэлц нэгжсийн бүтэц, утга зүйн тогтолцоо*. Уб., Хэл бичгийн ухааны докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл.
- Дамиранжав.** 2004. *Илийн соёл түүхийн материалын монгол үндэстний тусгай эмхтгэл*. Шинжааны ардын хэвлэлийн хороо.
- Лүнтү.** 1994. *Ойрад нутгийн аялгууны үгсийн хураангуй*. Өвөр Монголын Их Сургуулийн хэвлэлийн хороо.
- Норжин Ц.** 1992. *Нутгийн аялгууны үгсийн хураангуй*. Үндэсний хэвлэлийн хороо.
- Уяа Р.** 2017. *Уйгур, монгол хэлний дундын үгс*. Уб.
- Үнэнч, Ринчен Ч.** 2005. *Дөрвөн бичиг хавсаргасан ойрад аялгууны үгсийн толь*. Шинжааны Ардын хэвлэлийн хороо.
- Сүрүүн Н.** 1997. *Ойрад аялгууны өгүүлүүд*. Шинжааны ардын хэвлэлийн хороо.
- Төмөртоого Д.** 2018. *Монгол хэлний үгийн гаралын тайлбар толь*. Уб.
- Төмөрцэрэн Ж.** 2001. *Монгол хэлний үгийн сангийн судлал*. Уб.
- Чойжинжав.** 1987. *Ойрад аялгууны үг хэллэгийн материал*. Монгол төрлийн хэл аялгууны судлалын цуврал-21. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо.
- Уйгур-хятад онлайн орчуулгын толь.